

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

### “Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

**Огноо:** 2023 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Цаг: 12:05 -14:05

**Хурлын хэлбэр:** Биечлэн оролцох

**Хурлын дарга:** Ломбын Эрхэмбаяр

**Хурлын нарийн бичгийн дарга:** Болдбаатарын Нямбаяр

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо:** 186

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо:** 165,209,492 ширхэг.

**Хурлын ирц:** 82,6%

**Тусгай тэмдэглэл:**

**Хурлын дарга Л.Эрхэмбаяр:** Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Шангрила зочид буудлын Бүүлрүүм танхимд зохион байгуулав. Мөн хуралд оролцохоор цахимаар бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн гар утсанд 2023 оны 04-р сарын 22-ны өдрөөс эхлэн нэвтрэх код хаягийг санал өгөх кодын хамт илгээсэн болно. Бүртгэлийг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) хаягаар цахимаар бүртгэсэн.

Хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв.

### ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

**1 дэх асуудал:** “Түмэн шувуут” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;

**2 дахь асуудал:** Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, компанийн дүрмийг батлах

### ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

#### 1 ДЭХ АСУУДАЛ:

##### 1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. /тайланг хавсаргав./

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга А.Бакей нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

Мөн хөндөнгийн аудитаар ажилласан “Онч аудит” ХХК-ний партнер Б.Анхтайван компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийг танилцуулав.

##### 2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

##### 3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

| Зөвшөөрсөн                  |                                        | Татгалзсан                  |                                        | Түдгэлзсэн                  |                                        |
|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|
| Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа |
| 200,000,000                 | 165,209,492                            | 200,000,000                 | 165,209,492                            | 200,000,000                 | 165,209,492                            |
| Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   |
| 160,745,733                 | 100%                                   | 0                           | 0,00%                                  | 0                           | 0%                                     |

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрөв.

**2 ДАХЬ АСУУДАЛ:** Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, компанийн дүрмийг батлах

**1. Хэлэлцсэн нь:**

**Танилцуулсан:** “Агро фийд бордоо” Хязгаарлагдмал хариуцлагатай компани үүсгэн байгуулах тухай танилцуулга, шаардлага болон компани байгуулсанаар гарах үр дүн, давуу талуудын талаар ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр дэлгэрэнгүй тайлбар хийв.

**2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:**

“Агро фийд бордоо” Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, компанийн дүрмийг батлав.

**3. Энэ асуудлаар санал хураасан дүн:**

| Зөвшөөрсөн                  |                                        | Татгалзсан                  |                                        | Түдгэлзсэн                  |                                        |
|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|
| Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа |
| 200,000,000                 | 165,209,492                            | 200,000,000                 | 165,209,492                            | 200,000,000                 | 165,209,492                            |
| Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   |
| 160,741,901                 | 99,99 %                                | 570                         | 0,00%                                  | 8,262                       | 0,01%                                  |

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрч, 0,00% нь татгалзаж, 0,01% нь түдгэлзэв.

Энэхүү санал хураалтын дагуу тогтоолын төслийг баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох бичиг баримтыг хүргэх, дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нямбаяр/ нарт даалгаж байна.

**АСУУЛТ ХАРИУЛТ:**

**Хувьцаа эзэмшигч Амгалан:** Өнөөдөр гарах тогтоол дээх хувьцаа өсгөх тал дээр ямар нэгэн баримт бичиг гаргахгүй юм уу. Энэ талаар асууя гэж ирсэн та харин яричихлаа.

Хувьцааг өсгөх талаар ямар ажил төлөвлөсөн тэрнийгээ баталсан байдлаар ямар нэгэн баримт гаргахгүй юм уу гэж би хэлэх гээд байгаа юм.

**Л.Эрхэмбаяр:** Үнэнийг ярихад ойлголцдог хувьцаа эзэмшигчилтэй болж байгаа. Заримт нэг юман дээр таньд таалагдахгүй хариулт өгч магадгүй. Уучлаарай. Хувьцааг тэд болгож өсгөнө гэж ямар нэгэн тогтоол үйлдэж, бичиг гаргаж болдоггүй. Хувьцааны юнэ ямар байх нь валютын ханш, дайн байлдаан, улс төрийн нөхцөл байдал, улс орон явж байна уу үгүй юу, тухайн компаний ямар байх уу, эрсдэл гээд янз бүрийн юмнаас шалтгаалдаг. Чин сэтгэл бол байна. Чин сэтгэл чинь худлаа гэвэл одоо яая гэхэв. Юм ингэж л явдаг юмаа. Хэн ч тааж чадахгүй тэрний төлөө л явна.

**Хувьцаа эзэмшигч Цэвээнравдан:** Хувьцаа эзэмшигчийн хуралд ирээд тодорхой хэмжээний мэдээлэл авсанд баярлаж байна. Энд хэвлэмэл материал дээр байгаа мэдээлэл, танай вэб сайт дээр байгаа мэдээлэл, хөрөнгийн бирж дээр байгаа мэдээлэл, хамгийн дэлгэрэнгүй байсан мэдээлэл нь саяны Болд захирлын тавьсан мэдээлэл байлаа. Хувьцаа эзэмшигч бидэнд мэдээлэл их чухал. Ховдод хонио хариулаад явж байгаа хүн энэ 11,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй адил мэдээллээр хангагдах ёстой зарчмы хувьд. Иймд иэдллийг жигд байлгавал зүгээр байна. Сая ярьлаа. Сонголтоо зөв хийгээрэй. Хувьцаагаа зарах уу байх уу, Энэ бол зарчмын хувьд зөв юмаа. Тэгэхэд хувьцаа эзэмшигчдэд юу хэрэгтэй. Компаний тухай мэдээлэл. Өөрөөр хэлбэл компаний үнэ ханшид нөлөөлж болох иэдэ мэдээллийг тухайн компани шийдвэр гарсан дор нь 1 хоногийн дотор нийтэд мэдээлнэ. Цахим хуудсаараа, хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Энэ өнгөрсө хугацаанд танай цахим сайт дээр тавигдан мэдээллүүд, саяны мэдээллийг бид 1 жилийн дараа сонсож байна. Тэгэхээр тухай бүр нь мэдээлэх ёстой мэдээллүүд тэр дор нв яагаад нийтэд хүрэхгүй байна. Хувьцаа эзэмшигч бид хувьцаагаа зарах уу яах уу гэдэг шийдвэр гарах тийм мэдээлэл хувьцаа эзэмшигч бидэнд их чухал байна. Компаний юүйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүд гарсан дороо нийтэд тавигдах ёстой. Одоо энэ хурлын материал үзэхэд өнгөрсөн жил ТУЗ-аас үнэ ханшид нөлөөлөх хэдэн шийдвэр гарав, тэр нь хувьцаа эзэмшигч бидэнд яаж хүрэв. Энэ тал дээр жоохон хангалтгүй байна. ТУЗ-ийг өнөөдөр бид нар сонгосон. Иймэс та нар бидэнд ийм ийм ажил хийсэн гэдгийг тодорхой хэлж байх ёстой. Өнөөдрийн энэ хурал дээр гүйцэтгэх захирлын ажлын дүгнэлтийг ТУЗ-өөс яаж дүгнэсэн бэ. Манай гүйцэтгэх захирал ажлаа ийм биелүүлсэн, ийм төлөвлөгөөтэй байна. Тэдэн хувь нь биелсэн. Эдийн засгийн үзүүлэлтийн задаргааг бидэнд задалж оруулаа л даа. Томилолтын зардал яаж биелсэн. Цалингийн зардал хэд гарсан, яагаад илүү гарсан, яагаад хэмнэгдсэн юм бэ, хэний гавьяагаар хэмнэгдсэн бэ гэх зэрэг асуултанд хурлаасаа өмнө мэдээлэл авмаар байна. Цаашдаа компанийн засаглалын кодексийг сайн судлаад биелүүлэхийг хүсье. Сонголтоо хийх мэдээллээр цаг тухайд нь сайн хангамаар байна гэж хэлье.

**ТУЗ-ийн гишүүн Г.Мөнх-Эрдэнэ:** Таны хэлж байгаа шүүмжлэлийг 100 хувь хүлээн авч байна. Хамгийн гол нь мэдээлэл тархаах гэдэг асуудлыг үндсэн хариуцаж хийх газар нь Үнэт цаасны компаниуд юм байгаа юм. Би ч гэсэн өөрөө үнэт цаасны компаний захирал хүн . Энэ дээр муу ажиллаж байгаагаа мэдээд байгаа. Зөндөө санаачлага гаргаад явж байна. Түрүүний үзүүлдэг группт нэгдээрэй гээд байгаа нь мэдээлэл өгөх гээд байгаагийн 1 хэлбэр гэсэн үг. Нэг талаас. Нөгөө талаас бид компаниудаас мэдээллийг нь шаардаж авах ажил хийх ёстой юм байгаан үнэт цаасны компаниуд. Зөвхөн манайх биш зөндөө үнэт цаасны компаниуд байгаа. Нэг талаас шаардаж шаардаж гаргаж өгөхгүй бол компани өөрөө асуудалтай байна гэсэн үг. Ийм мэдээлэл авмаар байна

гэхэд гаргаж өгч байгаа бол компани ил тод нээлттэй байна гэж үзнэ. Тэгэхээр үнэт цаасны компаниудын хувьд бид мэдээллийг цаг тухай бүрт нь өгөх тал дээр анхаарч ажиллая гэж бодож байна. Яг хувьцаа эзэмшигч нарт хүргэх суваг өөрөө их чухал байдаг. Түмэн шувуут ХК нь 11,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй гэж байна. Энэ бүх хүнд яаж өгөх үү гэдэг суваг их чухал. Залгаж өгөх юм уу, уулзуулах ёстой юм уу, онлайнаар ойрхон ойрхон уулалт хийх ёстой юм уу, утас, и-мэйлд нь мэдээ явуулаад орхих юм уу гэх мэтчилэн хувилбарууд бас байгаа. Иймээс энэ тал дээр ярилцаж байгаад ахиц дэвшил гаргая гэдгийг ТУЗ-ийн даргадаа бас тавьмаар байна.

**Л.Эрхэмбаяр:** Заавал ийм тогтсон стандартад баригддагаа болих хэрэгтэй. Ганцхан тогтоолын заалт ТУЗ-ийн гишүүдэд хангалтгүй байна. Би тэрнийг чинь мэдрээд байна. Гүйцэтгэх багийнхан хувьцаат компаний удирдлага гэдгээ ойлго.

**Хувьцаа эзэмшигч Ганзориг:** Болд захирлаас 2 асуулт, Эрхэмбаяр даргаас 1 асуулт асууя. Сая тайлан дээр зээлийн хүүгийн төлөлт гэж байна. Өндөр хүүтэй зээл байгаад байх шиг байна. Эко бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа, ямар ч хаягдалгүй болж байгаа гэдгээ сурталчилаад ногоон хямд эх үүсвэртэй төслөө санхүүжүүлэх тал дээр ямар ажил хийгдэж байгаа вэ. Одоо зах зээлийн 21 хувийг хангадаг, цаашдаа 30 хүрэх гээд ажиллаж байгаа гэж байна. Түүнээс цааш яах вэ. Гадагшаа бордоо бусад малын махаа гаргах тал дээр ямар ажлууд хийгдэх вэ. Дараагийн асуулт бол би анх энэ компаний хувьцааг улс төрийн нөлөөтэй гээд авдаггүй байсан. Компаний үйл ажиллагаа сайн байгаад байхаар ерөнхийдөө өөрийн багцад оруулаад явсан. Тэгэхээр 2024 оны сонгууль болох гэж байна. Эрхэмбаяр дарга та улс төрд орох сонирхол байгаа юу. Монголын улс төр жоохон бохир яваад байдаг. Ямар үзэл бодолтой байгаа талаар мэдмээр байна.

**Ж.Болд:** Зээлийн хүү бол харьцангуй байгаа. Үндсэндээ 14 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй явж байгаа. Хамгийн өндөр байгаа зээлийн хувьд 1,5 хувийн хүүтэй зээлийн шугам байгаа. Ерөнхийдөө үйл ажиллагаанл зарцуулж байгаа хөрөнгө оруулалтын хувьд бол Азийн хөгжлийн банк, дээрээс нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 10 их наядын хөтөлбөр гэх мэт зээлүүд явж байгаа. Бусад байгууллагуудтай харьцуулахад зээлийн хүү бага байгаа. Ногоон зээлийн хувьд бордооны үйлдвэрт өмнө нь хийгдсэн ажлууд байгаад байгаа учраас шинээр юм хийгдэхээр бол тэр ногоон зээлд орж болох юм. Өмнө нь хийгдсэн ажлууд байгаса учраас тэр зээлийн зориулалтанд таарахгүй байгаад байгаа юм. Цаашид хийхээр ажлуудыг ногоон зээлд хамруулж болох байх. Ногоон зээлийг судалж байна. Цаашдаа зах зээлд 30 хувиас дээшээ яах вэ гэж байна. Бидэнд бас Б төлөвлөгөө байгаа. 2024 онд жилдээ 150 сая ширхэг өндөг үйлдвэрлээд байх уу. Нэг Монгол хүн жилд 130 ширхэг өндөг хэрэглэдэг. Тэгэхээр нилээн томоохон зах зээл байгаа. Тэгэхээр Түмэн шувуут-2 аж ахуй дээр өргөтгөлүүдийг нэмж хийхээр төлөвлөж байна. Өнөөдөр энэ талаар ярьсангүй. 3-аас дээш жил хийх ажлууд байгаа учир. Манай компаний хувьд үндсэн бүтээгдэхүүн өндөг, тэжээл байдаг. Эдгээрийг гадагшаа гаргана гэж зорихоосоо илүү эхний ээлжинд дотооддоо хэрэгцээг нь илүү сайн хангадаг болоход анхаарч ажиллаж байгаа. Мэдээж хонины махны аж ахуй бэлтгэгдэж байгаа. Хонины мах экспортод гаргах ажил цааш цаашдаа хийгдэх юм.

**Л.Эрхэмбаяр:** Надаас жил болгон энэ асуултг асуудаг юм. 25 тэрбум төгрөгийн борлуулалт хийчээд 9,5 тэрбум төгрөгийн татвар бусад татвар улсад төлжээ. Өөрөөр хэлбэл нийт борлуулалтынхаа 20 хувийг улсад тушаачихжээ. Нийт цэвэр ашиг маань дөнгөж 7 тэрбум юм ш дээ. Цэвэр ашгаасаа хамаагүй их юмыг татварт улсад төлжээ.

250-иад ажилчдын бүтэн 365 хоногт ажилласан хөлс хүчийг ингэж шавхачихаад, бидний борлуулалтын 20 хувийг авчихаад, цэвэр ашгийг дабльдаж шахуу авчихаад байж байгаа царай нь энэ. Тэгэхээр би улс төрд ормоор санагддагийн. Уур маань хүрдэгийн, бухимддагийн. Гэхдээ би 2 тэрбумаар орохгүй. Надад тийм илүү мөнгө байхгүй. Тийм утгагүй сонголтоо олон түмэн хийсээр л байвал энэ Монгол улс хөгжихгүй. Намайг мөнгөгүйгээр ард түмэн уг нь сонгох ёстой юм байгаан. Хэзээ тэгэхийг мэдэхгүй. Ингээд улс төрөөд яриад байвал бухимдаад хэдүүлээ яваад өгнө. Ингэхийгээд орхичихье.

**Хувьцаа эзэмшигч Нандинцэцэг:** Танилцуулга дээр бизнесийн 3 жилийн төлөвлөгөө байх болов уу гэж бодсон байхгүй байлаа. Цаашдаа төлөвлөгөөгөө энэ танилцуулганд аа оруулаад өгөөрэй гэж хүсч байна. Энэ танилцуулга нь үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүрдэг учраас мэдээлэл дутуу байна гэж харагдаж байна. Агро фийд компаний гүйцэтгэх захирлаар нь хэн гэж хүн тавигдах вэ. Хулийн этгээд байгуулахад ямар нэгэн урсгал зардал гардаг байгаа. Энэ урсгал зардлын тооцоог гаргасан болов уу. Боломжтой бол энэ тооцоог бидэнд хэлэх болов уу гэж бодож байна.

**Л.Эрхэмбаяр:** Дахиад л манай гүйцэтгэх багийн асуудал гарч ирнэ. Цаашдаа бид 2023 оны төлөвлөгөөгөө тавьж байя. Бид өөрөө өөрсдөө мэдэж байгаагаа болж байгаа гэж ойлгоод байгаа. Бид хийсэн, ярьсан бэлэн юм байгаа. Үүнийг л манай гүйцэтгэх багийнхан анхаараад өгөө. Олон дахин хэлмээргүй байна шүү. Компаний гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн зүгээс хэлэлцэж шийдвэрлэнэ.

**Хувьцаа эзэмшигч Байгалмаа:** Та бүгдэд амжилт хүсье. Хувьцаа эзэмшигчдийн амралтын хүрээлэн байгуулах тухай ярьж танилцуулж байсан. Тэр ажил ямар түвшинд яваа юм бол. Хувьцааны нийт 80 хувийг 2 гэр бүлийн 4 хүн эзэмшдэг, Бусад нь 19 хувь байсан. Анх IPO гаргахад та 4 хэдэн хувь эзэмшдэг байсан бэ.

**Л.Эрхэмбаяр:** 61- гарамын хажууд хонины аж ахуй байгаа. Тэнд ЕБС-ийн хүүхдүүдийг авайчдаг. Мал аж ахуйн соёл уламжлалтай танилцуулья гэсэн хэтийн төлөв бол байгаа. Газрын асуудал гээд бидэнд зөндөө бэрхшээлүүд байгаа. Хөөцөлдөөд явж л байна. 2-3 жилийн ажил байгаа гэж ойлгох хэрэгтэй. Ер нь мал аж ахуйн түүхийг ЕБС-ийн хүүхдүүдэд танилцуулдаг байх юм. Тахиятай, шувуутай, гахайтай, үнээтэй гэх мэт удамжлалт ал аж ахуйн соёлыг харуулсан байх юм. Анх IPO гаргахдаа 25 хувиа гаргасан, одоогоор 40 хүнтэй 80 хувь байгаа. Хувьцаа худалдаж авсан тухайгаа Болд захирал ярина.

**Ж.Болд:** Анх IPO гаргахад нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд үлдсэн 75 хувь 4 хүн дээр төвлөрсөн байсан. 2 үндсэн гол хувьцаа эзэмшигчид бол манай үүсгэн байгуулагчид. Үүсгэн байгуулагчдын хувьцааны тоо хэмжээ одоо болтол өөрчлөгдөөгүй. Манай гэр бүлийн хүн Л.Баяржаргал бид -ын хувьцаа тус бүр 7,5 хувь байсан. Одоо бол тус бүр 10 хувийг эзэмшиж байгаа. Нийт зах зээл дээрээс 5 хувийг буцаан худалдаж авсан гэсэн үг. Худалдаж авахдаа олон нийтэд нээлттэй мэдээллэж, ил тод иргэнийхээ хувиар зах зээл дээрээс худалдаж авсан.

**Хувьцаа эзэмшигч:** Улс оронл шувууны ханиад их гарч байна. Үүний эсрэг юу хийж байгаа вэ.

**Б.Болд:** Бид шувууны элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээр шувуугаа хамгаалах бодлого нилээн сайн барьж ажилладаг. Үүний нэг жишээ бол шувуугаа дэглээхэй байхаас нь авахуулаад 8 өвчний вакцин бүрэн ххамруулдаг. Энэ нь шувууны элдэв халдварт өвчнөөс сэргийлэх гол арга юм. Мөн мал эмнэлгийн эрүүл ахуй халдвар хамгааллын дүрмийг чанд баримталдаг юм. Мөн шувууны аж ахуйд гарах элдэв

халдварт өвчнөөс хамгаалсан шувууны даатгал байгаа. Мандал даатгал компанитай 3 дахь жилдээ хамтарч ажиллаж байна. Янз бүрийн эрсдэлээс хамгаалж шувуугаа даатгуулсан байгаа. Ийнхүү гэрээний дагуу хамгаалалт хийгдээд явдаг юм.

**Л.Эрхэмбаяр:** Саналын системд бас дараах асуултууд бичгээр ирсэн байна. Тус бүрт нь хариулаад явъя.

**Хувьцаа эзэмшигч:** Түмэн шувуут-2 төслийг хэзээ дуусгах вэ.

**Л.Болд:** Барилга байгууламжийг барьсан ч гэсэн Түмэншувуут -2 аж ахуйн үйлдвэрлэл 2024 оноос гарах юм. Барилгаа байна, тоног төхөөрөмжөө угсарна, шувуугаа өсгөж бойжуулна. Шувуунд өндөг үйлдвэрлэж эхлэх хугацаа байдаг. 2023 онд бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссан ч гэсэн 2024 оноос хойш үйлдвэрлэлийн тоо хэмжээ нэмэгдэнэ. Саяны танилцуулганд бас гарсан. 2023, 2024, 2025 оноос гээд тус тус байсан. Яг 2025 онд үйлдвэрлэлийн тоо хэмжээ 150 сая ширхэгт хүрэхээр байгаа юм.

**Хувьцаа эзэмшигч:** Бонд гаргах уу.

**Л.Эрхэмбаяр:** Бонд гаргахгүй ээ.

**Хувьцаа эзэмшигч:** Өнгөрсөн онуудын ногдол ашгаа хаанаас яаж авах вэ.

**Л.Эрхэмбаяр:** Үнэт цаасны компанидаа ханданаа.

**Хувьцаа эзэмшигч:** Түмэн шувуут үйлдвэрийг 2 зээ хүүтэй очиж танилцмаар байна. Тэгж болох уу.

**Л.Эрхэмбаяр:** Болно. Одоо ковид зүгээр болж байгаа болохоор танилцах аялалыг зохион байгуулна. Зарласан хугацаанд нь зарласан бүртгэлд нь хамрагдаад явж болно. Бүртгүүлээгүй үед очиход боломжгүй шүү.

**Хувьцаа эзэмшигч:** Том хувьцаа эзэмшигч хувьцаагаа зарж цөөлөх санал байна уу.

**Л.Эрхэмбаяр:** Би харин ч хувьцаагаа нэмэх бодолтой байгаа.

**Хувьцаа эзэмшигч:** Агро фийд бордоо ХХК нь ТУЗ байгуулах уу, удирдлага хэрхэн бүрдүүлэх вэ.

**Л.Эрхэмбаяр:** Удирдлагыг толгой компаниасаа судалж байж томилно.

**Хувьцаа эзэмшигч:** Өнгөрсөн оны ногдол ашгаа хаанаас авах вэ.

**Л.Эрхэмбаяр:** Таны үнэт цаасны дансанд орсон байгаа шүү. Та өөрөө сайн ойлголттой болоорой. Үнэт цаасны компанитайгаа л ярина.


**Л.Эрхэмбаяр:** За өөр асуулт хариулт дууссан байна.

**Үүгээр асуулт хариултын хэсэг өндөрлөв.**

**Тооллогын комиссын дүнг үндэслэн** Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 14:05 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА :  
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Л.ЭРХЭМБАЯР  
Б.НЯМБАЯР